



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/56

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Гурванцүүр  
өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг  
балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 27,673,000.00 (хорин долоон сая зургуун зуун далан гурван мянган) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасан байгууллагын балансад шилжүүлж данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Гурванцүүр өрхийн эрүүл мэндийн төв (З.Сарантуяа)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Отгондолоон бурхан өрхийн эрүүл мэндийн төвд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500191

D: lac \BL.Tushaal.docx

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2024 оны дүгээр сарын 02-ны  
өдрийн 5 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: СХД 6-р хороо Гурванцүүр ӨЭМТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024 оны .02.. сарын ...-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Dell computer	2022.03.15	ш	4	2,255,000.00	9,020,000.00	3,607,999.92	5,412,000.08		
2	Принтер элсон	2022.04.30	ш	1	738,000.00	738,000.00	225,500.00	512,500.00		
3	Камер	2022.05.31	ш	10	257,500.00	2,575,000.00	901,249.97	1,673,750.04		
4	Хаалт	2022.03.31	ш	1	14,620,000.00	14,620,000.00	5,117,000.97	9,502,999.03	Гурванцүүр ӨЭМТ	Отгондолоон Бурхан ӨЭМТ
5	Кушетик	2022.04.30	ш	1	350,000.00	350,000.00	58,333.40	291,666.60		
6	Үүдний тек	2020.10.31	ш	1	370,000.00	370,000.00	234,333.46	135,666.54		
	Дүн			16		27,673,000.00	10,144,417.72	17,528,582.29		